

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын
цэргийн командлагчийн 2018 оны 05 дугаар
сарын 07-ны өдрийн 1120 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

УХГ0025

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хугацаа	Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, хөрөнгийн эх үүсвэр	Хариуцах, хамтрах байгууллага
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1. Алба хаагчийн хувийн болон харилцааны соёлыг дээшлүүлэн, эерэг хандлага төлөвшүүлж, ажлын хариуцлага, сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.							
1.	1. Алба хаагчдын харилцааны болон биеэ авч явах соёлыг төлөвшүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулж, алба хаагч бүрт зөв дадал хэвшүүлэх.	1.1.1. Албаны сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөнд алба хаагчдын хувийн болон байгууллагын соёлыг төлөвшүүлэх сургалтын цаг, сэдвийг тусган, сургалтыг үр дүнтэй, тогтмол зохион байгуулж, ижил түвшинд хөгжүүлэх.	-Хөтөлбөр, төлөвлөгөөнд цаг, сэдвийг тусгасан байх, -Сургалтын модуль, гарын авлага, ном, видео хичээл бэлтгэж хүргүүлсэн байх, -Сургалт зохион байгуулж хэвшсэн байх.	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёл төлөвшихөд ахиц гарахад нөлөөлсөн байна.	2018-2020	Шаардагдах зардлыг тухайн жилийн төсвөөс санхүүжүүлэх.	ХНСХ, ЦДЦСНТ, АБХ, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		1.1.2. Алба хаагчдын харилцааны болон биеэ авч явах соёлыг төлөвшүүлэх чиглэлээр соён гэгээрүүлэх ажлыг үр дүнтэй, тогтмол явуулж хэвших.	Нөлөөллийн шинжтэй оновчтой арга хэлбэр /гарын авлага, зурагт хуудас, зөвлөмж, тэмцээн, уралдаан, аян, зөрчлийн оноо гэх	Алба хаагчдын хувийн соёл дээшилж, харилцааны болон биеэ авч явах байдалд эерэг өөрчлөлт гарна.	2018-2020	Шаардагдах зардлыг тухайн жилийн төсвөөс санхүүжүүлэх.	ХНСХ, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага

			мэт /-үүдийг сонгож, ажил, арга хэмжээ зохион байгуулсан байх.				
		1.1.3. Алба хаагчдын гадаад үзэмжийг дээшлүүлж, цэрэгжилч, жагсаалч байдал, хуульч, дүрэмч ажиллагааг мөрдөж хэвшүүлэх.	Цэрэгжилч, жагсаалч, хуульч, дүрэмч ажиллагааг хэвшүүлэх чиглэлээр нөлөөллийн шинжтэй /сургалт, гарын авлага, зурагт хуудас, видео хичээл, загвар стандарт, уралдаан гэх мэт/ ажил, арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцсон байх.	Хууль тогтоомжийг мөрдөж хэвшсэн, дүрэмт хувцас, сахилга ёс зүйн зөрчилгүй хамт олныг бүрдүүлсэн байна.	2018-2020	-	АБХ, ХШУДАХ, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
2.	2. Байгууллагын тогтоосон хэм хэмжээ, дүрэм, журмын хэрэгжилтийг сайжруулж, ажил үүргийн соёлыг төлөвшүүлэх.	1.2.1. Байгууллагын үйл ажиллагааны дүрэм, журам /код/-ыг сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангах.	Холбогдох дүрэм, журмын талаарх сургалт, сурталчилгаа зохион байгуулж, мөрдүүлсэн байх.	Дүрэм, журмын хэрэгжилт хангагдана.	2018-2020	-	ХуХ, ХНСХ, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		1.2.2. Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод заасан зорилго, зорилтыг хангахад чиглэсэн ажил, арга хэмжээг шинэлэг хэлбэр /зураг, комик, гарын авлага гэх мэт/-ээр зохион байгуулах.	Шинэлэг арга, хэлбэрийг оновчтой ашигласан байх.	Ажлын байрны чиг үүргээ ухамсарласан чадварлаг алба хаагч болж хөгжинө.	2018-2020	Шаардагдах зардлыг тухайн жилийн төсвөөс санхүүжүүлэх.	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		1.2.3. Дүрэм, журмын хэрэгжилт, ажлын байр /албан тушаал/-ны зорилго,	Ажлын гүйцэтгэлийг ил тод, бодитой	Дүрэм, журмын хэрэгжилт хангагдаж, алба	2018-2020	-	Цагдаа, дотоодын цэргийн

		зорилтод заасан ажил, үүргийн гүйцэтгэлийг бодитой, шударгаар үнэлж, дүгнэх.	дүгнэсэн байх.	хаагчдын ажиллах урам зориг, итгэл үнэмшил нэмэгдэнэ.			анги, байгууллага
3.	3. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад анх болон шилжин томилогдсон алба хаагчдыг богино хугацаанд дасан зохицуулах, эерэг хандлагыг төлөвшүүлж, албандаа итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх.	1.3.1. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх томилогдсон алба хаагчдад зориулсан багц /байгууллагын лого бүхий гарын авлага, үнэмлэх, энгэрийн тэмдэг, дэвтэр, үзэг гэх мэт/ бий болгож, гардуулах, тэдэнд албаараа бахархах, итгэл үнэмшил төрүүлэх.	Багц бий болгож, анх томилогдсон алба хаагчдад хүндэтгэлтэйгээр гардуулж, хэвшүүлсэн байх.	Албаараа бахархах итгэл үнэмшил төрж, ажиллах урам зориг нэмэгдэнэ.	2018-2020	Шаардагдах зардлыг тухайн жилийн төсвөөс санхүүжүүлэх.	ХНСХ, СААА, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		1.3.2. Байгууллагын түүхэн замнал, алдар гавъяаг сурталчлан таниулах, залгамж холбоог сайжруулах.	-Байгууллагын түүхэн замнал, алдар гавъяаг мөнхжүүлсэн алдрын тасалгаа /музей, булан/ байгуулсан байх. -Анх болон шилжин томилогдсон алба хаагчдад сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, хэвшсэн байх.	Байгууллагын түүхэн замнал, алдар гавъяаг мэддэг, туршлагаас суралцаж, өв тэгш алба хаагч болж төлөвшинө.	2018-2020	-	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		1.3.3. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, үр дүнг тооцох.	Байгууллагын даргаас хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад тогтмол хяналт тавьж, үр	Алба хаагч ажил албандаа богино хугацаанд дасан зохицож, мэргэжлийн чиг баримжаатай	2018-2020	-	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага

			дүнг тогтоосон хугацаанд тооцож хэвшсэн байх.	болсон байна.			
Зорилт 2. Хамт олны нэгдмэл байдлыг ханган, багаар ажиллах чадварыг сайжруулж, байгууллага, нэгжийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ.							
4.	1. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын түүхэн уламжлал, туршлагаасаа байнга суралцаж, байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх.	2.1.1. Баг, хамт олныг нэгтгэх, түүхэн уламжлал, туршлагаас суралцахад чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг олон талт хэлбэрээр зохион байгуулах.	Алба хаагчдын оролцоог жигд хангасан арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, үр дүнг тооцсон байх.	Баг, хамт олны эв нэгдэл, зэрэг хандлага төлөвшинө.	2018-2020	Шаардагдах зардлыг тухайн жилийн төсвөөс санхүүжүүлэх.	ХНСХ, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		2.1.2. Багийн ажиллагааг сайжруулах идэвхжүүлэлтийн шинэлэг арга /кейс, дасгал ажиллуулах, дүрд тоглох гэх мэт/ хэлбэрийг ашиглах.	Шинэлэг арга хэлбэрийг ашиглаж багийн үйл ажиллагааг идэвхжүүлсэн байх.	Алба хаагчдын ур чадвар, ажлын бүтээмж дээшилнэ.	2018-2020	-	ХНСХ, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		2.1.3. Байгууллагын имиж /дүр төрх/-ийг сайжруулж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх.	Байгууллага бүр өөрийн имижийг сайжруулах арга замаа хамт олноороо хэлэлцэн тодорхойлж, бусдаас ялгарах, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлсэн ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх.	Байгууллагын гадаад соёл, иргэдийн үнэлэмж, итгэл үнэмшил дээшилнэ.	2018-2020	-	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
5.	2. Хамт олны шинэлэг санаа, бүтээлч ажиллагааг дэмжиж нэвтрүүлэх,	2.2.1. Шинэлэг санал, санаачилга, бүтээлч ажиллагааг дэмжиж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх,	Үйл ажиллагаандаа шинэлэг санаа, бүтээлч	Байгууллагын үйл ажиллагаа сайжирч, бүтээмж	2018-2020	Шаардагдах зардлыг тухайн жилийн төсвөөс	Цагдаа, дотоодын цэргийн анги,

	сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх.	урамшуулах.	ажиллагааг нэвтрүүлсэн байх.	нэмэгдэнэ.		санхүүжүүлэх.	байгууллага
		2.2.2. Алба хаагч, хамт олны нэвтрүүлсэн шинэлэг, бүтээлч ажлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх "Шилдгийн булан" байгуулах.	Алба хаагчдын ажлын үр дүнг сар бүр дүгнэж, "Шилдгийн булан"-д байршуулж, урамшуулсан байх.	Алба хаагчдын ажлын бүтээмж, урам зориг нэмэгдэнэ.	Сар бүр	Шаардагдах зардлыг тухайн жилийн төсвөөс санхүүжүүлэх.	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		2.2.3. Хамт олноороо сайн үйлсийн аянд нэгдэх, тусламж шаардлагатай алба хаагчдад дэмжлэг үзүүлэх.	-Хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд /алба хаагчдаас аливаа хэлбэрээр мөнгө татахгүй/ зохион байгуулсан байх. -Нийгэмд тустай олон талт арга хэмжээ зохион байгуулсан байх.	Хамт олны эв нэгдэл, байгууллагын нэр хүнд өснө.	2018-2020	-	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
6.	3. Ажлын зохион байгуулалтыг оновчтой болгож, үүргээ ухамсарласан, алба хаагч бүрийн тэгш оролцоог хангасан, нэгдмэл хамт олны бүрдүүлэх.	2.3.1. Байгууллагын дотоод сүлжээний ашиглалтыг нэмэгдүүлж, алба хаагчдын ажиллах урам зоригийг сэргээн, сэдэлжүүлэх "Өглөөний мессеж" илгээх, тогтмол мэдээ, мэдээллээр хангах.	-Байгууллагын дотоод сүлжээгээр "Өглөөний мессеж /мэндчилгээ, ажил үүрэг, зорилт, сэдэлжүүлэлт гэх мэт"-ийг алба хаагчдад хүргэж хэвшсэн байх.	Алба хаагчдын ажлын бүтээмж, урам зориг нэмэгдэнэ.	2018-2020	-	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		2.3.2. Ажлын зохион байгуулалтыг сайжруулж, багийн гишүүн бүр хариуцсан ажилдаа эзэн болж ажиллах хандлагыг төлөвшүүлэх ажил, арга хэмжээг зохион байгуулах.	Алба хаагчдын хандлагыг өөрчлөх сургалт, арга зүйн хэлбэрийг судалж, нэвтрүүлсэн байх.	Алба хаагчийн хандлага сайжирна.	2018-2020	-	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага

		2.3.3. Багийн удирдлага, харилцан хамтын ажиллагааг сайжруулж, үр дүнг үнэлж, удирдлагаас дэмжиж ажиллах.	Багийн гишүүдийн ажлын үзүүлэлтийг үнэлж, дүгнэх шалгуурыг бодитой болгож, шударгаар, ил тод үнэлж дүгнэн, урамшуулсан байх.	Алба хаагчдын идэвх, оролцоо сайжирна.	2018-2020	-	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
Зорилт 3. Удирдлагын манлайлал, үр нөлөөг дээшлүүлж, зөрчилдөөнийг бууруулан, байгууллагын үйл ажиллагааг төгөлдөржүүлнэ.							
7.	1. Удирдах ажилтны манлайлал, удирдлагын сэтгэл зүй, арга барилыг сайжруулж, эрх мэдлийн соёлыг төлөвшүүлэх.	3.1.1. Байгууллагын удирдах ажилтнууд зөв үлгэр дууриалал үзүүлж, манлайлах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх чиглэлээр идэвх, шинэлэг санал санаачилга гарган ажиллах.	Удирдах ажилтнуудаас сахилга ёс зүйн зөрчил дутагдалд холбогдоогүй байх.	Удирдах ажилтны манлайлал дээшилнэ.	2018-2020	-	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		3.1.2. Удирдахуйн ухааны оновчтой арга барил, удирдлагын сэтгэл зүйд суралцаж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байх.	-Сургалтад хамрагдаж, шинэлэг арга барилыг эзэмшсэн байх. -Алба хаагчдын сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах чиглэлээр бодитой ажил зохион байгуулсан байх.	Байгууллагын үйл ажиллагаа сайжирч, бүтээмж нэмэгдэнэ.	2018-2020	-	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		3.1.3. Алба хаагч нартайгаа хүнлэг зөв боловсон харьцаж, тэдний байр сууринд өөрийгөө тавьж удирддаг байх.	Ажил хэрэгч харьцаа, соёлтой нөхөрсөг, уур амьсгал бүрдүүлэх, чадвар эзэмшсэн байх.	Зөрчилдөөн буурч, хамт олны уур амьсгал сайжирна.	2018-2020	-	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага

8.	2. Ажлын байран дахь зөрчил, зөрчилдөөнийг бууруулах, шийдвэрлэх, алба хаагчдыг урамшуулах, идэвхжүүлэх оновчтой арга барилыг нэвтрүүлэх.	3.2.1. Ажлын байран дахь зөрчил, зөрчилдөөнийг бууруулах, шийдвэрлэх чиглэлээр санал, хүсэлтийг хүлээн авч сонсох, "Шилэн хайрцаг" ажиллуулах.	Байгууллагад тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, зөрчилдөөнийг бууруулах чиглэлээр ажил, арга хэмжээ зохион байгуулсан байх.	Байгууллагын хөгжилд бодит нөлөө үзүүлж, зөрчилдөөн буурч, хамт олны уур амьсгал сайжирна.	2018-2020	-	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		3.2.2. Иргэд, мөрдөн шалгах ажиллагааны оролцогчдын сэтгэл зүй, зан харьцааны хэв маягт тохируулан харьцах арга барилд суралцах, нэвтрүүлэх.	Алба хаагчдад сургалт явуулах, зөвлөмж өгөх, гарын авлага, видео сургалт хийх зэргээр үр дүнтэй ажил зохион байгуулсан байх.	Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаа, харилцаа, ёс зүй зөрчсөн талаар ирүүлсэн гомдол мэдээллийн тоо буурна.	2018-2020	-	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		3.2.3. Алба хаагчдын албан тушаал дэвших, шагнал урамшууллын тогтолцоог хүний нөөцийн бодлогын баримт бичиг, ЦБҮАЖ-д заасны дагуу ил тод явуулж, алба хаагчдыг идэвхжүүлэх /эрхийн бичиг олгох, аяллаар явуулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх гэх мэт/, урам зориг өгөх ажлыг сайжруулах.	Байгууллага дахь зөрчил, зөрчилдөөний судалгааны суурь үзүүлэлтийн үнэлгээ 0.5-аас дээш хувиар өссөн байх.	Хамт олон, алба хаагч хоорондын зөрчилдөөн буурахад нөлөөлнө.	2018-2020	-	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
9.	3. Эрүүл ахуй, аюулгүй байдал, хөдөлмөр хамгааллын	3.3.1. Алба хаагчдын ая тухтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх, техник, хэрэгслээр хангах, сайжруулах ажлыг эрчимжүүлэх.	Бусад төрийн болон хувийн байгууллагуудад нэвтрүүлсэн шинэлэг орчин, нөхцөлийг судалж,	Алба хаагчдын ажлын таатай орчин бүрдэж, сэтгэл ханамж, ажлын бүтээмж нэмэгдэнэ.	2018-2020	Шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлэх.	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага

	стандарт шаардлага хангасан, алба хаагчдын ажил үүргээ хэвийн гүйцэтгэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх.		нэвтрүүлсэн байх.				
		3.3.2. Алба хаагчдын стресс, уур бухимдал, алжаал тайлах /сэтгэл зүйн, цайны, эмчилгээний, угаалгын, саун, душ/ өрөөг бий болгож, тохижуулах.	-Амрах, тайвшруулах, уулзалт, сэтгэл заслын болон саун, душны өрөөг бий болгож, үйл ажиллагаа явуулдаг байх. -Угаалга /хими цэвэрлэгээний/ ажиллуулах, алба хаагчдад хөнгөлттэй үнээр ашиглуулах боломж, нөхцөлийг судалж, хэрэгжүүлсэн байх.	Алба хаагчдын стресс, ядаргаа, бухимдал, мэргэжлээс шалтгаалах өвчлөл буурч, хувийн соёл дээшилнэ.	2018-2020	Шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлэх.	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		3.3.3. Байгууллагын харъяа амралт, сувиллын газруудыг түшиглэн "Гэр бүлийн амралт, хөгжлийн төв" байгуулж, алба хаагчид гэр бүлээрээ чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх.	Амралт, хөгжлийн төвийг бий болгож, үйл ажиллагааг эхлүүлсэн байх.	Алба хаагчдын гэр бүлийн харилцаа, ажлын бүтээмж дээшлэхэд нөлөөлнө.	2018-2020	-	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
Зорилт 4. Байгууллагын соёлыг сурталчилж, иргэд, олон нийтийн дэмжлэг туслалцаа, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.							
10.	1. Мэдээлэл түгээх арга зам, давтамж, зохицуулалтыг боловсронгуй болгож, үйл ажиллагааны ил	4.1.1. Албан ёсны цахим хуудсыг хөгжүүлэх, мэдээллийг цаг тухай бүрт нь шинэчлэх, иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр байршуулах.	Цахим хуудасны агуулга, хэлбэрийг боловсронгуй болгож, хэрэглээг нэмэгдүүлсэн байх.	Мэдээллийн ил тод байдал хангагдаж, хэрэглэгчийн тоо нэмэгдэнэ.	2018-2020	-	ХМТ, МТХТ, Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага

	тод, нээлттэй байдлыг хангах.	4.1.2. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчийн алдар гавъяа, сайн үйлсийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах.	Цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаа, алдар гавъяа, хүндрэл бэрхшээлийг харуулсан /нэвтрүүлэг, кино, нийтлэл, дуу, клип/ мэдээ, мэдээлэл өргөнөөр нэвтрүүлсэн байх.	Иргэд, олон нийтийн дунд цагдаагийн байгууллагын нэр хүнд өсч, итгэл үнэмшил нэмэгдэнэ.	2018-2020	Шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлэх.	ХМТ, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		4.1.3. Олон нийтийг хамруулж, идэвхжүүлсэн /PR, нээлттэй хэлэлцүүлэг, аян/ арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцох.	Удирдамж, төлөвлөгөөний дагуу үр дүнтэй ажил, арга хэмжээ зохион байгуулж, үнэлэлт, дүгнэлт өгсөн байх.	Байгууллагын хөгжлийг дэмжих шийдэл, гарцыг тодорхойлоход дэмжлэг болно.	2018-2020	Шаардагдах зардлыг тухайн жилийн төсвөөс санхүүжүүлэх.	ХМТ, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
11.	2. Алба хаагчдад хүргэх мэдээ, мэдээллийг оновчтой, хүртээмжтэй, чанартай зохион байгуулж, хэвших.	4.2.1. Алба хаагчдад "Police app"-ыг сурталчлах, хэрэглэж хэвшүүлэх, алба хаагчдыг мэдээллээр хангах ажлын чанарыг сайжруулах.	Алба хаагчдад "Police app"-ыг хэрэглэх чадвар эзэмшүүлж, хэрэглээг хэвшүүлсэн байх.	Алба хаагчид мэдээ, мэдээллээр шуурхай хангагдана.	2018-2020	-	ХМТ, МТТ, Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		4.2.2. Дүрс, дууны болон дотоод сүлжээ ашиглан мэдээлэл түгээх, хүртээмжийг нэмэгдүүлэх.	Техник, технологийн орчин нөхцөлийг бүрдүүлж, ашиглалтыг сайжруулсан байх.	Алба хаагчид мэдээллийг хүртээмжтэй хүлээн авах нөхцөл бүрдэнэ.	2018-2020	Шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлэх.	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		4.2.3. Алба хаагч бүр өөрийн байгууллагын талаарх эерэг мэдээллийг сурталчлах, түгээх.	Албандаа хүндэтгэлтэй хандаж, эергээр сурталчлан таниулах хандлага төлөвшүүлэх сургалт,	Албаны нэр хүнд өсөхөд нөлөөлнө.	2018-2020	-	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага

			нөлөөллийн арга хэмжээ хэрэгжүүлсэн байх.				
12.	3. Байгууллагын соёлыг сурталчлахад иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудын дэмжлэг, туслалцааг авах, хамтран ажиллах арга хэлбэрийг боловсронгуй болгох.	4.3.1. Байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлах "LED самбар" ажиллуулах.	Олон нийтийн газар, гудамж, талбайд сурталчилгааны "LED самбар" байршуулсан байх.	Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилж, мэдээллээр хангагдана.	2018-2020	Шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлэх.	СAAA, ХМТ, МТХТ, Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		4.3.2. Иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх боршуур, комик, сэтгүүл, зурагт самбар, плакат хэвлүүлж байршуулах, сурталчлах.	Хууль эрх зүйн мэдээллийг агуулсан гарын авлага, материалыг бэлтгэж, түгээсэн байх.	Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилж, цагдаа, иргэдийн хамтын ажиллагаа сайжирна.	2018-2020	-	ХМТ, МТТ, Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага
		4.3.3. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлахад олон нийтийн дэмжлэг, туслалцааг авч, хамтран ажиллах.	Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудын дэмжлэг туслалцааг хуулийн хүрээнд авч, хамтран ажилласан байх.	Хамтын ажиллагаа сайжирч, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд ахиц гарна.	2018-2020	-	ХМТ, МТТ, Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага